



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР

7 ХОНОГИЙН ХҮНСНИЙ БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ТАНИЛЦУУЛГА



2024 оны 11 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар Улаанбаатар хотын гол нэрийн барааны үнэ өмнөх сараас өөрчлөлтгүй байгаа бол өмнөх 7 хоноогоос **0.2 хувиар өссөн** байна.


Улаанбаатар хотод байрладаг, иргэд, олон нийт ихээр үйлчлүүлдэг 13 хүнсний зах, худалдааны төв, супермаркетад хийсэн 21 нэр төрлийн 32 хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн 2024 оны 11 дугаар сарын 3 дахь долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 15 нэрийн барааны үнэ **(46.8%) тогтвортой**, 8 нэрийн барааны үнэ **(25.0%) өссөн**, 9 нэрийн барааны үнэ **(28.2%) буурсан** байна. Үүнд:

- **Махны дундаж үнэ**

2024 оны 11 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 14168 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 17899 төгрөгийн үнэтэй тус тус худалдаалагдаж байна.

Өмнөх долоо хоногтой харьцуулахад үхрийн ястай махны үнэ 0.8 хувиар өсөж 17899 төгрөг, үхрийн цул махны үнэ 0.7 хувиар буурч 20264 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Зураг 1. Үхрийн нэг килограмм махны дундаж үнэ, төгрөг




Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Үхрийн ястай махны дундаж үнэ												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	10 960	11 700	12 280	11 540	11 375	10 950	10 090	9 755
2020	10 535	11 415	11 665	11 735	11 940	12 640	12 760	11 760	11 235	10 855	11 075	11 210
2021	11 615	12 605	12 670	13 850	13 960	14 770	14 800	13 700	13 420	13 280	13 345	13 495
2022	14 060	14 000	14 260	14 530	15 145	15 390	15 120	14 240	13 730	13 565	13 275	13 395
2023	13 520	14 245	14 955	16 750	18 493	20 100	19 466	16 723	16 277	15 690	15 542	15 846
2024	16 437	17 150	17 624	18 209	18 418	18 159	18 475	17 735	18 138	17 865	17 899*	

Хонины ястай махны дундаж үнэ												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	9 820	10 430	10 045	9 700	9 640	9 095	7 710	7 635
2020	8 705	9 600	9 765	9 835	10 125	10 385	10 650	9 870	9 170	8 715	8 635	8 580
2021	9 040	10 460	10 705	12 320	12 390	12 695	12 440	11 380	10 975	11 005	10 775	10 850
2022	11 485	11 940	12 585	12 620	12 705	12 805	12 360	11 530	11 025	10 270	9 805	9 920
2023	10 440	11 350	12 680	14 065	15 396	16 598	15 766	13 387	12 703	12 010	11 834	12 080
2024	12 926	13 776	13 917	14 632	16 290	16 322	15 339	14746	14 510	14 245	14 168*	

*III долоо хоногийн ажиглалтаар

Зураг 2. Хонины нэг килограмм махны дундаж үнэ, төгрөг



Өмнөх долоо хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 0.5 хувиар өсөү 14168 төгрөг, хонины цул махны үнэ 0.1 хувиар буурч 14955 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины ястай мах “М-Март” дэлгүүрт хамгийн хямд буюу 14500 төгрөгөөр, Харин үхрийн ястай мах “Хархорин” захад хамгийн хямд буюу 13500 төгрөгөөр худалдаалагдаж байна.

• Гурилын үнэ


“Алтан тариа” нэрийн савласан нэг кг гурилын дундаж үнэ дээдийн дээд зэрэг нь 4222 төгрөг, дээд зэрэг нь 3207 төгрөг, 1-р зэрэг нь 2323 төгрөг, 2-р зэрэг нь 1430 төгрөг байна.

Худалдан авагч ихээр үйлчлүүлдэг “Барс” худалдааны төвд “Алтан тариа” нэрийн савласан нэг кг гурилын дундаж үнэ дээдийн дээд зэрэг нь 4200 төгрөг, дээд зэрэг нь 3200 төгрөг, 1-р зэрэг нь 2500 төгрөг, 2-р зэрэг нь 1600 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байна.




“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 2360-2530 төгрөгийн үнэтэй байна. “Е март” худалдааны төвд “Атар” талхыг хамгийн хямд буюу 2360 төгрөгөөр, харин “Сансар” супермаркетэд 2530 төгрөгөөр худалдаалж байна.

Зураг 3. Нэг килограмм будааны үнэ, төгрөг




Зураг 4. Нэг килограмм савласан гурилын үнэ, төгрөг



- Хүнсний ногооны үнэ

Өмнөх долоо хоногтой харьцуулахад монгол төмс 0.8 хувиар өсөж 1362 төгрөг, монгол байцай 0.2 хувиар буурч 2435 төгрөг, монгол лууван 1.1 хувиар буурч 2525 төгрөг, монгол сонгино 3.7 хувиар өсөж 3563 төгрөг, хүрэн манжин 2.8 хувиар өсөж 3314 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Зураг 5. Нэг килограмм хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг



Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:

Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2024 XI.18

Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2024 оны VIII-XI сар

Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2017-2024 оны XI сар

Хавсралт 4. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2024 XI.18

Хавсралт 5. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2024 оны VIII-XI сар

Хавсралт 6. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2022-2024 он

Хавсралт 7. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2024.XI.18